



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/135

Улаанбаатар хот

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал,
шалгуур үзүүлэлт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.5, 8 дугаар зүйлийн 8.3.10, 8.4, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8¹.1.1 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, Хороодын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалыг нэгдүгээр, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баталсан аргачлал, шалгуур үзүүлэлтийн дагуу холбогдох байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2017 оны 3 дугаар улиралд багтаан танилцуулахыг Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Одонбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ШАРАВЖАМЦ

000000448

Биеийн тамир, спортын газрын даргын
2017 оны 05-р сарын 04-ны өдрийн
А/... тоот тушаалын 1.-р хавсралт

135

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөхөд энэхүү аргачлалыг үндэслэл болгоно.

1.2. Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагуудын үйл ажиллагаанд Монгол улсын хууль тогтоомж, төрийн бодлого, дүрэм, журам, стандарт, зааврын хэрэгжилтийг сайжруулах, үйл ажиллагааны үр нөлөө, өгөөжийг дээшлүүлэх, удирдлагыг үнэн, зөв мэдээлэл, эрсдэлийн удирдлагаар хангахад энэхүү аргачлалын зорилго оршино.

1.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилт нь биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, цогц хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, шийдвэр, аймаг, нийслэлийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг нягтлан тогтоох, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, шалтгааныг тогтоож түүнийг засаж залруулах чиглэл, арга хэмжээг тодорхойлох, шаардлагатай тохиолдолд бодлогын шинэ зорилтыг дэвшүүлж, бодлогын хувилбар, санал, дүгнэлт, зөвлөмжөөр дэмжихэд чиглэгдэнэ.

1.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Шударга, хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус байх;
- Явц, тайлан, дүгнэлт нь ил тод байх;
- Үр дүнд чиглэсэн байх;
- Тоо баримт, судалгаа, албан ёсны мэдээлэл зэрэг нотолгоонд тулгуурласан байх;
- Хэрэглэгч, сонирхогч талуудын оролцоог хангасан байх.

1.4. Аймаг, нийслэлийн Биеийн тамир, спортын байгууллага энэхүү аргачлалын дагуу өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, "Орон нутгийн биеийн тамир, спортын хөгжлийн хандлага" сэдэвт хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг (дүгнэх аргачлалын дагуу) боловсруулна.

1.5. Аймаг, нийслэлийн Биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур үзүүлэлттэй байна.

Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, тайлан ирүүлэх, нэгтгэл

2.1. Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллага нь харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд явуулсан үйл ажиллагааныхаа үр дүндээ хяналт-шинжилгээ, үнэлгээг уг тушаалын нэгдүгээр хавсралтын дагуу хийнэ.

2.2. Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллага нь хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээндээ үндэслэн **“Орон нутгийн биеийн тамир, спортын хөгжлийн хандлага”** тайланг боловсруулж жил бүрийн 2 дугаар сарын 10 –ний дотор Биеийн тамир, спортын газарт хэвлэмэл болон цахим байдлаар ирүүлнэ.

2.3. **“Орон нутгийн биеийн тамир, спортын хөгжлийн хандлага”** тайланг крилл үсгийн **Arial 12** хэмжээтэй **Word** программ ашиглан боловсруулж цахим хэлбэрээр Биеийн тамир, спортын газрын төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн (цахим хаягаар)-д ирүүлнэ.

2.4. БТСГ-ын Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн аймаг, нийслэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон тайланг нэгтгэж, улсын хэмжээний тайланг боловсруулж жил бүрийн 03 дугаар сарын 20-ны дотор гаргана.

2.5. БТСГ-ын Гадаад харилцаа, статистик, мэдээлэл, технологийн хэлтэс тайлангийн тоон үзүүлэлтэнд хяналт хийнэ.

Гурав. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй

3.1. Үйл ажиллагааны төлөвлөгөө (нийлүүлэх бүтээгдэхүүний жагсаалт)-нд төлөвлөсөн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа, зарцуулах төсөв хөрөнгө, хариуцах ажилтан буюу орц, хүрэх үр дүн буюу гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхой тусгаж, батлуулсан байна.

3.2. Үйл ажиллагааны зорилтын хүрэх үр дүн буюу төлөвлөсөн гарц нь тодорхой, хэмжигдэхүйц, бодитой, цаг хугацааны хязгаар бүхий шалгуур үзүүлэлттэй байна. Гүйцэтгэлийн бодит үр дүнг төлөвлөсөн зорилттой (төлөвлөгөөтэй) харьцуулж, түүний өсөлт, бууралтыг тооцоолох аргаар үр дүнд суурилсан хяналт-шинжилгээг гүйцэтгэнэ.

3.3. Зорилт, гүйцэтгэлийн зөрүүний шалтгааныг илрүүлэх, тасалдлыг нөхөх, илүү өндөр түвшний зорилго дэвшүүлэх боломж, нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр тухайн орон нутгийн биеийн тамир, спортын үйл ажиллагаанд үр дүнгийн үнэлгээг өгнө.

3.4. Хяналт-шинжилгээ хийхдээ баримт бичиг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь очиж шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

3.5. Аймаг, нийслэлийн Биеийн тамир, спортын газар “**Орон нутгийн биеийн тамир, спортын хөгжлийн хандлага**” мониторингийн тайланг тус журмын 2.1, 2.2 дахь хэсгийн дагуу боловсруулна.

3.6. Аймаг, нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь 2017 оны “Орон нутгийн биеийн тамир, спортын хөгжлийн хандлага” мониторингийн тайланг суурь болгон дараа оны тайланг боловсруулах ба өсөлт, бууралтыг харьцуулна.

3.7. Биеийн тамир, спортын бодлогын хэмжээний томоохон болон шаардлагатай гэж үзсэн үйл ажиллагаанд Биеийн тамир, спортын газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу хяналт- шинжилгээ үнэлгээ хийнэ.

Дөрөв. Дүгнэлт

4.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ шалгуур үзүүлэлтийн 1-6 дугаар бүлгийг индексийн аргаар, 7 дугаар бүлгийг аргачлалын дагуу оноогоор дүгнэж тайланг боловсруулна.

4.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээг нэгтгэн дүгнэхдээ БТСГ-ын хэлтэс, албадаас Ажлын хэсэг байгуулан ажиллана.

4.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээг дүгнэхдээ аймаг, дүүргүүдийг шалгуур үзүүлэлт бүрийг харьцуулан үзэж, дүгнэлт гарган зөвлөмжийг хүргүүлнэ.

4.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний нийт шалгуур үзүүлэлтийг нийлбэр онооны дунджаар байр эзлүүлнэ. Үндсэн 6 үзүүлэлтийн нийлбэр дүн тэнцсэн тохиолдолд нэмэлт 7 дахь үзүүлэлтийг харгалзан үзнэ.

4.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлгээг газар дээр нь хийх, сургалт зохион байгуулах, сургалтын материал, ном, товхимол, гарын авлага хэвлүүлэх, урамшуулалд зарцуулах зардал хөрөнгийг Биеийн тамир, спортын газрын төсөвт жил бүр тусгана.

Аргачилал /индекс/

№	Шалгуур, үзүүлэлт	Дүгнэх аргачлал	Тайлбар
Нэг. Санхүүгийн үйл ажиллагааны үзүүлэлт			
1	Нэг хүнд ногдох Спортын хэмжээний санхүүжилтийн индекс	T1- Орон нутгийн спортын арга хэмжээний төсөв	САХСИ=T1/H1
		H1- Орон нутгийн нийт хүн амын тоо	
2	Нэг хүнд ногдох нийтийн биеийн тамирын арга хэмжээний санхүүжилтийн индекс	T2- Орон нутгийн нийтийн БТ-ын нийт санхүүжилт	НБТСИ=T2/H2
		H2- Орон нутгийн нийт хүн амын тоо	
3	Ивээн тэтгэгчдийн санхүүжилтийн индекс	T3- Ивээн тэтгэгчдийн санхүүжилтийн нийт хэмжээ	ИТСИ=T3/H3
		H3- Орон нутгийн нийт хүн амын тоо	
4	Төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн индекс	T4- Төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн нийт хэмжээ	ТХСИ=T4/H4
		H4 - Орон нутгийн нийт хүн амын тоо	
5	Нэг хүнд ногдох Орон нутгийн нийт санхүүжилтийн индекс	T5- Орон нутгийн нийт төсөв	ОНСИ=T5/H5
		H5- Орон нутгийн нийт хүн амын тоо	
Хоёр. Хүний нөөцийн үзүүлэлт			
6	Хүний нөөцийн индекс	H1- Орон нутгийн нийт хүн амын тоо	ХНИ=H1/M1
		M1- Биеийн тамир спортын мэргэжилтэй ажилтны тоо	
7	Дасгалжуулагчдын индекс	C2- Спортоор хичээллэгчдийн тоо	ДИ=C2/D2
		D2- Дасгалжуулагчдын тоо	
8	Арга зүйчдийн индекс	H3- Орон нутгийн нийт хүн амын тоо	АЗИ=H3/A3
		A3- Арга зүйчдийн нийт тоо	
9	БТС-ын байгууллагад ажиллаж буй санхүү болон үйлчилгээний ажилчдын индекс	H4- БТС-ын байгууллагад ажиллагчдын нийт тоо	СҮИ=H4/C4
		C4- Санхүү болон үйлчилгээний ажилчдын тоо	

Гурав. Спортын барилга байгууламжийн хүртээмж, ашиглалтын индекс				
10	Спорт заалны хүртээмжийн индекс	C1- Спорт заалны нийт талбайн хэмжээ	ХИ1=C1/Н1	
		Н1- Орон нутгийн нийт хүн амын тоо		
11	Спортын барилга байгууламжийн цаг ашиглалтын индекс	C2-Спортын зориулалтаар ашигласан нийт цаг	АИ1=C2/Н2	
		Н2- Жилийн турш ажиллах нийт цаг		
12	Спортын гадна талбайн хүртээмжийн ашиглалтын индекс	C3- Спортын гадна талбайн нийт хэмжээ	ХИ2=C3/Н3	
		Н3- Орон нутгийн нийт хүн амын тоо		
13	Фитнесс төвүүдэд хичээллэгчдийн хүртээмжийн индекс	C4- Фитнесс төвүүдэд хичээллэгчдийн нийт тоо	ФИ1=C4/Н4	
		Н4- Орон нутгийн нийт хүн амын тоо		
Дөрөв. Биеийн тамирын үзүүлэлт				
14	Бие бялдрын хөгжилт, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдагсдын индекс	X1- Хамрагдсан хүний нийт тоо	СИ1=X1/Н1	
		Н1- Нийт хүн амын тоо		
15	03-05 насны ББХЧТТС-д хамрагдагсдын индекс	X2- Сорилд хамрагдсан хүүхдийн тоо	СИ2=X2/Н2	
		Н2- Нийт 03-05 насны хүүхдийн тоо		
16	06-17 насны ББХЧТТС-д хамрагдагсдын индекс	X3- Сорилд хамрагдсан хүүхдийн тоо	СИ3=X3/Н3	
		Н3- Нийт 06-17 насны хүүхдийн тоо		
17	15-64 насны ББХЧТТС-д хамрагдагсдын индекс	X4- 15-64 насны сорилд хамрагдсан хүний тоо	СИ4=X4/Н4	
		Н4- 15-64 насны нийт хүний тоо		
18	Засгийн газрын 05 дугаар тогтоолын хүрээнд хийгдсэн ажилд хамрагдагсдын индекс	X5- Хамрагдагсдын нийт тоо	05И=X5/Н5	
		Н5- Орон нутгийн нийт хүн амын тоо		
19	СӨБ-ын насны хүүхдүүдийн дунд зохион явуулсан арга хэмжээнд хамрагдагсдын индекс	X6- Хамрагдсан хүүхдийн тоо	СӨБИ=X6/Н6	
		Н6- Нийт хүүхдийн тоо		


20	Залуучуудын дунд зохион явуулсан арга хэмжээнд хамрагдагсдын индекс	X7- Хамрагдсан залуучуудын тоо	ЗИ=X7/H7	
		H7- Нийт залуучуудын тоо		
21	Ахмадуудын дунд зохион явуулсан арга хэмжээнд хамрагдагсдын индекс	X8- Хамрагдсан ахмадуудын тоо	АИ=X8/H8	
		H8- Нийт ахмадуудын тоо		
22	Насанд хүрэгчдийн дунд зохион явуулсан арга хэмжээнд хамрагдагсдын индекс	X9- Хамрагдсан насанд хүрэгчдийн тоо	НИ=X9/H9	
		H9- Нийт насанд хүрэгчдийн тоо		
Тав. Спортын үзүүлэлт				
23	Спортоор хичээллэгч өсвөр үеийнхний индекс	C1- Спортоор хичээллэгч өсвөр үеийнхний тоо	ӨҮСИ=C1/H1	
		H1- Нийт хүүхдийн тоо		
24	Спортоор хичээллэгч залуучуудын индекс	C2- Спортоор хичээллэгч залуучуудын тоо	ЗСИ=C2/H2	
		H2- Нийт залуучуудын тоо		
25	Спортоор хичээллэгч насанд хүрэгчдийн индекс	C3- Спортоор хичээллэгч насанд хүрэгчдийн тоо	НХСИ=C3/H3	
		H3- Нийт насанд хүрэгчдийн тоо		
26	Спортоор хичээллэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн индекс	C4- Спортоор хичээллэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	ХБИСИ=C4/H4	
		H4- Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо		
27	Улсын аварга шалгаруулах амжилтын индекс	C5- Улсын аварга шалгаруулах тэмцээнээс авсан медалийн тоо	АИ=C5/H5	
		H5- Нийт медалийн тоо		
28	Үндэсний спортын төрлөөр зохион явуулсан арга хэмжээний индекс	C6-Үндэсний спортын төрлөөр зохион явуулсан нийт арга хэмжээний тоо	ҮСИ=C6/H6	
		H6-Байгууллагын жилийн нийт арга хэмжээний тоо		
29	Өвлийн спортын төрлөөр зохион явуулсан арга хэмжээний индекс	C7-Өвлийн спортын төрлөөр зохион явуулсан нийт арга хэмжээний тоо	ӨСИ=C7/H7	
		H7-Байгууллагын жилийн нийт арга хэмжээний тоо		
30	Багийн спортын төрлөөр зохион явуулсан арга хэмжээний индекс	C8-Багийн спортын төрлөөр зохион явуулсан нийт арга хэмжээний тоо	БСИ=C8/H8	
		H8-Байгууллагын жилийн нийт арга хэмжээний тоо		

Зургаа. Шигшээ багийн үзүүлэлт

31	Шигшээ багийн тамирчдын индекс (өсвөр, залуучууд, насанд хүрэгчид)	Ш1- Спортоор хичээллэгч (өсвөр, залуучууд, насанд хүрэгчид)-ийн нийт тоо	ШБИ1=Ш1/Н1	
		Н1- Шигшээ багийн тамирчдын тоо		
32	Шигшээ багийн дасгалжуулагчийн индекс (өсвөр, залуучууд, насанд хүрэгчид)	Ш2- Дасгалжуулагчид /өсвөр, залуучууд, насанд хүрэгчид/-ийн нийт тоо	ШБИ2=Ш2/Н2	
		Н2- Шигшээ багийн дасгалжуулагчдын тоо		
33	Шигшээ багийн уралдаан, тэмцээнд зарцуулсан зардлын индекс	Ш3- Байгууллагын нийт төсөв	ШБИ3=Ш3/Н3	
		Н3- Шигшээ багийн төсөв		
34	Жилд шигшээ багийн дасгалжуулагчийн цалингийн зардлын индекс	Ш4- Байгууллагын нийт төсөв	ШБИ4=Ш4/Н4	
		Н4- Цалингийн нийт зардал		
35	Шигшээ багийн амжилтын индекс	Ш-5 УАШТ-нээс авсан медалийн тоо	ШБИ5=Ш5/Н5	
		Н5- Нийт медалийн тоо		

Долоо. Нэмэлт үзүүлэлт

36	Гадаад харилцааны хөгжлийн тоон үзүүлэлт	1-3 оноогоор үнэлнэ	3 - бүрэн хангалттай 2 - хангалттай 1 - хангалтгүй	-3 болон түүнээс дээш үйл ажиллагаа хийгдсэн бол – 3 оноо -1-2 үйл ажиллагаа хийгдсэн бол – 2 оноо -Гэрээ хийгдэх шатандаа бол – 1 оноо
37	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийсэн тоо (спорт, биеийн тамир, шигшээ баг, бусад г.м)			-5 болон түүнээс дээш сургалт зохиосон (оролцсон) бол – 3 оноо -3 сургалт зохиосон (оролцсон) бол – 2 оноо -1 буюу түүнээс доош – 1 оноо
38	Ажилчдын мэргэжил, ур чадвар сайжруулах талаар сургалт зохион байгуулсан /хамруулсан/ тоо			
39	Цахим мэдээлэл, веб сайт ашиглалтын байдал	Өөрийн байгууллагын цахим хуудсыг хэрхэн ашигласан, мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан байдлыг харгалзан үзнэ.		



Биеийн тамир, спортын газрын даргын
2017 оны 05-р сарын 04-ны өдрийн
А/... тоот тушаалын 2-р хавсралт

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ (тайлбар)**

№	Үзүүлэлт	Тайлбар
Нэг. Санхүүгийн үйл ажиллагааны үзүүлэлт		
1	Спортын арга хэмжээний нийт зардал	Спортын арга хэмжээнд зарцуулсан нийт зардлаас нэг хүнд хэрхэн ногдож байгаагаар илэрхийлэгдэнэ
2	Биеийн тамирын арга хэмжээний зардал	Биеийн тамирын арга хэмжээнд зарцуулсан нийт зардлаас нэг хүнд хэрхэн ногдож байгаагаар илэрхийлэгдэнэ
3	Орон нутгийн нийт зардал	Орон нутгийн нийт тэмцээн уралдааны төсвөөс нэг хүнд хэрхэн ногдож байгаагаар илэрхийлэгдэнэ
4	Ивээн тэтгэгчдийн нийт зардал	Ивээн тэтгэгчдийн нийт мөнгөн зардлаас нэг хүнд хэрхэн ногдож байгаагаар илэрхийлэгдэнэ
5	Төсөл, хөтөлбөрийн зардал	Төсөл, хөтөлбөрийн зардал нэг хүнд хэрхэн ногдож байгаагаар илэрхийлэгдэнэ
Хоёр. Хүний нөөцийн үзүүлэлт		
6	Биеийн тамир, спортын мэргэжилтэй ажилчдын тоо	Биеийн тамир, спортын байгууллагад ажилладаг спортын мэргэжилтэй нэг ажилчинд хэдэн хүн ногдож байгаагаар илэрхийлэгдэнэ
7	Дасгалжуулагчдын нийт тоо	Нэг дасгалжуулагчид спортоор хичээллэдэг хэдэн хүн ногдож байгаагаар илэрхийлэгдэнэ
8	Арга зүйчдийн нийт тоо	Биеийн тамир, спортын байгууллагад ажилладаг нэг арга зүйчид хэдэн хүн ногдож байгаагаар илэрхийлэгдэнэ (орон тооны бус арга зүйчдийг тайлбарт тусган бичиж болно)
9	БТС-ын салбарт ажилладаг санхүүгийн болон үйлчилгээний ажилчдын тоо	Биеийн тамир, спортын байгууллагад ажилладаг санхүүгийн болон үйлчилгээний ажилчид нийт ажилчдын хэдэн хувийг эзэлж байгаагаар илэрхийлэгдэнэ
Гурав. Спортын барилга байгууламжийн хүртээмж, ашиглалтын үзүүлэлт		
10	Спорт заалны тоо, хэмжээ /м ² /	Нэг хүнд ногдох Спорт заалны талбайн хэмжээгээр илэрхийлэгдэнэ (аймаг болон сум, дүүргийн бүх заалны нэр, талбайн

		хэмжээг тайлбар дээр оруулсан байна)
11	Спортын гадна талбай тоо, хэмжээ /м ² /	Нэг хүнд ногдох спортын гадна талбайн хэмжээгээр илэрхийлэгдэнэ (аймаг болон сум, дүүргийн бүх гадна талбайн нэр, хэмжээг тайлбар дээр оруулсан байна)
12	Спорт заалны БТС-ын зориулалтаар ашигладаг цаг	Нэг жилийн турш спорт заалыг зориулалтын дагуу хэдэн цаг ашигласнаар илэрхийлэгдэнэ
13	Фитнесс төвүүдийн тоо, хэмжээ /м ² /	Фитнесс төвүүдийн нийт талбай нэг хүнд хэдэн м ² ноогдож байгаагаар илэрхийлэгдэнэ
Дөрөв. Биеийн тамирын үзүүлэлт		
14	Бие бялдрын хөгжилт, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан нийт хүн амын тоо, хувь, үнэлгээ тус бүрийн хувь	Бие бялдрын хөгжилт, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан хүн амын тоо нийт хүн амын хэдэн хувийг эзэлж байгаагаар (үнэлгээ тус бүр хэдэн хувь эзэлж байгаагаар) илэрхийлэгдэнэ. А, В үнэлгээтэй хүмүүсийн эзлэх хувийг тайлбарт заавал оруулна.
15	03-05 насны Бие бялдрын хөгжилт, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан нийт хүүхдийн тоо, хувь	Бие бялдрын хөгжилт, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд 03-05 насны нийт хүүхдийн хэдэн хувь хамрагдсанаар илэрхийлэгдэнэ. А, В үнэлгээтэй хүүхдийн эзлэх хувийг тайлбарт заавал оруулна.
16	06-17 насны Бие бялдрын хөгжилт, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан нийт хүүхдийн тоо, хувь	Бие бялдрын хөгжилт, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд нийт 06-17 насны хүүхдийн хэдэн хувь хамрагдсанаар илэрхийлэгдэнэ. А, В үнэлгээтэй хүүхдийн эзлэх хувийг тайлбарт заавал оруулна.
17	15-64 насны Бие бялдрын хөгжилт, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан нийт хүний тоо, хувь	Бие бялдрын хөгжилт, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд нийт 15-64 насны хүүхдийн хэдэн хувь хамрагдсанаар илэрхийлэгдэнэ. А, В үнэлгээтэй хүмүүсийн эзлэх хувийг тайлбарт заавал оруулна.
18	Засгийн газрын 05 дугаар тогтоолын хүрээнд хийгдсэн ажил, хамрагдсан хүний тоо, хувь	15-аас дээш насны хүмүүсийн хамрагдалтын хувиар илэрхийлэгдэнэ (арга хэмжээ, хамрагдсан хүний тоог тайлбарт тусгасан байна)
19	СӨБ-ын насны хүүхдүүдийн дунд зохион явуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүүхдийн тоо, хувь	02-05 насны хүүхдүүдийн хамрагдалтын хувиар илэрхийлэгдэнэ (арга хэмжээ, хүүхдийн тоог тайлбарт тусгасан байна)
20	Залуучуудын дунд зохион явуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо, хувь	Залуучуудын хамрагдалтын хувиар илэрхийлэгдэнэ (арга хэмжээ, хүүхдийн тоог тайлбарт тусгасан байна)
21	Ахмадуудын дунд зохион явуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо	Ахмадуудын хамрагдалтын хувиар илэрхийлэгдэнэ (арга хэмжээ, хүүхдийн тоог тайлбарт тусгасан байна)

22	Насанд хүрэгчдийн дунд зохион явуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо	Насанд хүрэгчдийн хамрагдалтын хувиар илэрхийлэгдэнэ (арга хэмжээ, хүүхдийн тоог тайлбарт тусгасан байна)
Тав. Спортын үзүүлэлт		
23	Спортоор хичээллэдэг өсвөр үеийнхий тоо, хувь	Спортоор хичээллэдэг өсвөр үеийнхний хүүхдүүдийн хамрагдалтын хувиар илэрхийлэгдэнэ
24	Спортоор хичээллэдэг залуучуудын тоо, хувь	Спортоор хичээллэдэг залуучуудын хамрагдалтын хувиар илэрхийлэгдэнэ
25	Спортоор хичээллэдэг насанд хүрэгчдийн тоо, хувь	Спортоор хичээллэдэг насанд хүрэгчдийн хамрагдалтын хувиар илэрхийлэгдэнэ
26	Спортоор хичээллэдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хувь	Спортоор хичээллэдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамрагдалтын хувиар илэрхийлэгдэнэ (тоог тайлбарт тусгасан байна)
27	Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон төрөл, медалийн тоо, хувь	УАШТ-нээс авсан медалийн хувиар илэрхийлэгдэнэ
28	Өвлийн спортын төрлөөр зохион явуулсан арга хэмжээ, хамрагдсан хүний тоо	Өвлийн спортыг дэмжих чиглэлээр хэдэн арга хэмжээний хувиар илэрхийлэгдэнэ (төрөл, хамрагдсан хүний тоо, чанарыг тайлбарт тусгана)
29	Багийн спортын төрлөөр зохион явуулсан арга хэмжээ, төрөл, хамрагдсан хүний тоо	Багийн спортыг дэмжих чиглэлээр хэдэн арга хэмжээний хувиар илэрхийлэгдэнэ (төрөл, хамрагдсан хүний тоо, чанарыг тайлбарт тусгана)
30	Үндэсний спортын төрлөөр зохион явуулсан арга хэмжээ, төрөл, хамрагдсан хүний тоо	Үндэсний спортыг дэмжих чиглэлээр хэдэн арга хэмжээний хувиар илэрхийлэгдэнэ (төрөл, хамрагдсан хүний тоо, чанарыг тайлбарт тусгана)
Зургаа. Шигшээ багийн үзүүлэлт		
31	Шигшээ багийн төрөл, тамирчдын тоо (өсвөр, залуучууд, насанд хүрэгчид)	Шигшээ багийн тамирчдын эзлэх хувиар илэрхийлэгдэнэ (төрөл бүрээр тайлбарт тусгана)
32	Шигшээ багийн дасгалжуулагчийн тоо (өсвөр, залуучууд, насанд хүрэгчид)	Шигшээ багийн тамирчдын нэг дасгалжуулагчид ногдох хувиар илэрхийлэгдэнэ (төрөл бүрээр тайлбарт тусгана)
33	Жилд Шигшээ багийн тэмцээн уралдаанд зарцуулсан зардал	Тухайн жилийн төсөвт харьцуулсан хувиар илэрхийлэгдэнэ 9төрөл бүрээр тайлбарт тусгана)
34	Жилд Шигшээ багийн дасгалжуулагчийн цалинд зарцуулсан зардал	Тухайн жилийн төсөвт харьцуулсан хувиар илэрхийлэгдэнэ. / төрөл бүрээр тайлбарт тусгана. /

35	Шигшээ багийн жилд оролцсон тэмцээний тоо, медалийн тоо (алт, мөнгө, хүрлээр)	Улсын аварга шалгаруулах тэмцээнээс авсан медалийн хувиар илэрхийлэгдэнэ (оролцсон тэмцээн, авсан нийт медалийн тоо, төрөл бүрээр тайлбарт тусгана)
Долоо. Нэмэлт үзүүлэлт		
36	Гадаад харилцаа, холбоо тогтоосон үйл ажиллагаа (тоо)	Хэдэн оронтой ямар чиглэлээр хичнээн үйл ажиллагаа тогтоосон (хамтрсан) үр дүн хэрхэн гарснаар илэрхийлэгдэнэ
37	Ажилчдын мэргэжил, ур чадвар сайжруулах талаар сургалт зохион байгуулсан (хамруулсан) тоо	Өөрийн ажилчид, арга зүйчид, дасгалжуулагчдыг ямар сургалтанд хэдэн удаа хамруулсан болон сургалтыг өөрийн орон нутагт хэрхэн зохион явуулсан үр дүн хэрхэн гарснаар илэрхийлэгдэнэ
38	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийсэн тоо (спорт, биеийн тамир, шигшээ баг, бусад г.м)	Тухайн байгууллагын ажилчид шинжилгээ, судалгааны ажил (илтгэл) хэдэн удаа, ямар сэдвээр хийсэн үр дүн хэрхэн гарснаар илэрхийлэгдэнэ
39	Цахим мэдээлэл, веб сайт ашиглалтын байдал	Өөрийн байгууллагын цахим хуудсыг хэрхэн ашигласан, мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ.